



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 1156

Шивээговь сум

Хөрөнгө шилжүүлэх комисс томилох
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нутаг дэвсгэрт ашиглалтгүй байгаа 5 дугаар байрыг орон сууцны зориулалтаар “Чойр хайрхан сүмбэр” ХХК-д шилжүүлж, хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ж.Батмөнх

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

О.Болормаа

(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

А.Нандинцэцэг


(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Түвшинжаргал

(Нягтлан бодогч)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг комиссын дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212019